

## МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДИЙГ БҮРТГЭХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд, мөнгөн зээлийн үйл ажиллагааг байнга, ашиг олох зорилгоор эрхлэх иргэний үйл ажиллагаанд тавигдах нөхцөл шаардлагыг тогтоож, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг бүртгэх, бүртгэхээс татгалзах, түдгэлзүүлэх, сэргээх, бүртгэлийг хүчингүй болгох, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

1.2.1.үйл ажиллагаа нь ил тод нээлттэй байх;

1.2.2.талуудын тэгш оролцоог хангах;

1.2.3.бизнесийн ёс зүйтэй байх;

1.2.4.хувийн ашиг сонирхолыг хэрэглэгчийн ашиг сонирголоос дээгүүр тавихгүй байх;

1.2.5.зээлдэгчийн эрх, үүрэг, зээлийн бүтээгдэхүүний нөхцөлийн талаар танилцуулдаг байх;

1.2.6.мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байх;

1.3. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь дараах эрхтэй:

1.3.1.зээлийн гэрээний үүргийг хангуулахаар зээлдэгчээс хөдлөх эд хөрөнгийг барьцаанд бариулахыг шаардах;

1.3.2.зээлийн гэрээгээр харилцан тохиролцсон үүргээ биелүүлэх, үүргийн гүйцэтгэлийг хангуулахыг зээлдэгчээс шаардах;

1.3.3.зээлдэгчийн эд хөрөнгийн байдал доройтож зээлийг буцаан төлөх чадваргүй болох нөхцөл байдал бий болох, эсхүл болсон бол зээлдүүлэгч зээл олгохоос татгалзах, эсхүл олгосон зээлийг буцаан төлөхийг шаардах;

1.3.4.бүртгэлгүй этгээд мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа тохиолдолд бүртгэх байгууллагад мэдээлэх.

1.4. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь дараах үүрэгтэй:

1.4.1.хууль тогтоомжийг сахин биелүүлэх;

1.4.2.хуулиар ногдуулсан албан татвар төлөх;

- 1.4.3.өөрийн үйл ажиллагааны талаар үнэн зөв мэдээлэл өгөх;
- 1.4.3.барьцаа хөрөнгийн үнэлгээг зах зээлийн жишиг үнэд үндэслэн үндэслэлтэй тогтоох;
- 1.4.4.гэрээний хугацаанд барьцаа хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах;
- 1.4.5.барьцааны зүйл устах, үнэ нь ихээхэн буурах бодит нөхцөл бий болсон тохиолдолд барьцаалуулагчид нэн даруй мэдэгдэх;
- 1.4.6.зээлдүүлэгчийг зээлийн бүтээгдэхүүний нөхцөл, зээлийн дансны мэдээлэлтэй танилцах боломжоор хангах;
- 1.4.7.сэжиг бүхий эд зүйлийн талаар цагдаагийн байгууллагад мэдэгдэх;
- 1.4.8.өөрийн буруугаас учруулсан хохирлыг нөхөн төлөх;
- 1.4.9.Хорооноос тогтоосон зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөх.

### **Хоёр. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тавигдах шаардлага**

2.1. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд нь Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

- 2.1.1.Компанийн тухай хуульд заасны дагуу үүсгэн байгуулагдсан байх;
- 2.1.2.хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулах мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь тухайн иргэний хууль ёсны орлого, хуулийн этгээдийн хувьд санхүүгийн жилийн үйл ажиллагааны цэвэр ашиг болон хуримтлагдсан ашиг байх;
- 2.1.3.барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааны дотоод журамтай байх;
- 2.1.4.үнэт эдлэлийг шалгаж, хэмжих Стандартчилал хэмжилзүйн үндэсний төвөөс баталгаажсан зориулалтын багаж, хэрэгсэл, урвалж бодисоор хангагдсан байх;
- 2.1.5.цахим мэдээллийн санд мэдээлэл илгээх, хүлээн авах, дотоод бүртгэл мэдээллийг хөтлөх боломжтой компьютер, техник, тоног төхөөрөмжтэй байх;
- 2.1.6. барьцаанд хүлээн авсан эд хөрөнгийг хадгалах тусгай өрөө, шаардлага хангахуйц төмөр шүүгээ (сейф)-тэй байх;

2.2. Энэхүү журмын 2.1.3-г заасан барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааны дотоод журамд зээлдэгч, зээлдүүлэгчийн эрх, үүрэг, зээлийн бүтээгдэхүүний нэр төрөл, зээлийн гэрээ байгуулах, өөрчлөх, дуусгавар болгох нөхцөл, зээлийн хүү, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавих, зээлдүүлэгчийн буруугаас барьцаанд хүлээн авсан хөдлөх эд хөрөнгөд учруулсан хохирлыг нөхөн төлөх, барьцаалагч, барьцаалуулагчийн эрх, үүрэг, барьцаа хөрөнгийн үнэлгээг тооцох аргачлал, барьцааны шаардлагыг хангах, худалдах, барьцааны эрх дуусгавар болох, мөнгөн зээлийн үйл ажиллагаатай холбоотой дотоод бүртгэл хөтлөх, түүнийг цахим мэдээллийн санд мэдээлэх болон эрх бүхий байгуулагатай мэдээлэл солилцох, хэрэглэгчийг хамгаалах зохицуулалтыг тусгасан байна.

2.3. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн үйл ажиллагаа явуулах ажлын байр нь хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байх ба ажлын байрны нөхцөл шаардлагыг хангасныг нотлох дараах баримт бичгийг бүрдүүлж, бүртгэх байгууллагад ирүүлнэ:

2.3.1.ажлын байрны ариун цэвэр, эрүүл ахуйн орчин, цахилгаан болон галын аюулгүй байдлын шаардлага хангасныг нотлох эрх бүхий байгууллагын дүгнэлт;

2.3.2.гэрээт харуул хамгаалалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжтэй аюулгүй байдлын чиглэлээр байгуулсан хамтран ажиллах гэрээний хувь;

2.3.3.үйл ажиллагаа явуулах ажлын байр нь өөрийн өмчлөл, эзэмлийн байр бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хувь, түрээсийн байр бол түрээсийн гэрээний хувь;

2.4. Байнга, ашиг олох зорилгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэн нь хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

2.4.1.иргэний эрх зүйн бүрэн чадамжтай этгээд байх;

2.4.2.мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь тухайн иргэний татвар төлсний дараах хууль ёсны орлого байх;

2.4.3.барьцаанд хүлээн авсан эд хөрөнгө, гэрээ хэлцлийг хадгалах шаардлага хангахуйц төмөр шүүгээ (сейф)-тэй байх;

2.5. Байнга, ашиг олох зорилгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэнд хуулийн 5.1.6, 7.3-д заасан шаардлага хамаарахгүй.

2.6. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан нь хуулийн 5.1.9-д заасан шаардлагыг хангасныг нотлох дараах баримт бичгийг бүрдүүлж, бүртгэх байгууллагад ирүүлнэ:

2.6.1.хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний хувь;

2.6.2.хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлага нь журмын 3-р хавсралтаар баталсан эрх бүхий албан тушаалтны тодорхойлолт, анкет;

2.6.3.мэргэжлийн дипломны хуулбар;

2.6.4.мөнгөн зээлийн үйл ажиллагааны журмын талаарх гүйцэтгэх удирдлагын сургалтад хамрагдсаныг нотлох сертификатын хувь эсхүл сургалт явуулсан эрх бүхий байгууллагын тодорхойлолт;

2.6.5.хуулийн 5.1.10-т заасан гэмт хэрэгт хариуцлага хүлээж байсан эсэх талаарх эрх бүхий байгууллагын тодорхойлолт;

2.6.6.хугацаа хэтэрсэн зээлийн гэрээгээр хүлээсэн аливаа өр төлбөргүй талаарх лавлагаа;

2.6.7.эрх бүхий албан тушаалтан, холбогдох этгээд нь Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдэд тавигдах шалгуурыг хангасныг нотлох баримт бичиг;

2.6.8.боловсон хүчин, ажилтантай байгуулсан эрх бүхий этгээдийн томилсон шийдвэрийн хувь, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт;

2.7. Байнга, ашиг олох зорилгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэн нь энэхүү журмын 2.6 дахь хэсгийн 2.6.3-2.6.6-д заасан шаардлагыг хангасан байна.

**Гурав. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг бүртгэх, бүртгэхээс татгалзах**

3.1. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэхээр өргөдөл гаргасан этгээд нь энэхүү журмын хавсралтаар батлагдсан СЗХ09001 маягтын дагуу гаргасан өргөдөл, 2(А) дугаар хавсралтад заасан баримт бичгийг бүрдүүлж, бүртгэх байгууллагад хэвлэмэл болон цахимаар ирүүлнэ.

3.2. Бүртгэх байгууллагын эрх бүхий албан тушаалтан шаардлагатай тохиолдолд өргөдөл гаргагчаас ирүүлсэн баримт бичгийн талаар холбогдох этгээдээс тодруулж, дүгнэлт гаргуулж, лавлагаа авч болно.

3.3. Бүртгэх байгууллагын эрх бүхий албан тушаалтан өргөдөл гаргагч хуулийн этгээдийн үйл ажиллагаа явуулах ажлын байр, тоног төхөөрөмж, программ хангамж нь энэхүү журмаар тогтоосон шаардлагыг хангасан эсэхийг газар дээр нь шалгаж, танилцаж болно.

3.4. Бүртгэх байгууллага өргөдөл гаргагчаас ирүүлсэн баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор хянаж, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл /цаашид “бүртгэл” гэх/-д бүртгэх бөгөөд хугацааг зохих шаардлага хангасан, бүрдэл бүрэн баримт бичиг ирүүлсэн өдрөөс эхлэн тооцно.

3.5. Энэхүү журмын 3.4 дахь хэсэгт заасан хугацааг шаардалгатай гэж үзвэл бүртгэх байгууллага ажлын 5 өдрөөр нэг удаа сунгаж болох бөгөөд энэ тухай хүсэлт гаргасан этгээдэд албан бичгээр мэдэгдэнэ.

3.6. Өргөдөл гаргагч нь Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон энэхүү журамд заасан шаардлагыг бүрэн хангасан гэж үзвэл Санхүүгийн зохицуулах хорооны дарга тушаал, Аймаг, нийслэлийн Засаг дарга захирамж гаргах ба эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн хувийн дугаар, гэрчилгээ олгож, зохих журмын дагуу бүртгэлийн цахим санд бүртгэж, нийтэд мэдээнэ.

3.7. Бүртгэх байгууллагын шийдвэрийг үндэслэн мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг Улсын бүртгэл ерөнхий газарт бүртгүүлснээр үйл ажиллагаа эхлүүлсэнд тооцох бөгөөд улсын бүртгэлийн гэрчилгээний болон дүрмийн хуулбарыг бүртгэх байгууллагад хүргүүлнэ.

3.8. Бүртгэх байгууллага мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэхээр хүсэлт гаргасан этгээдийг дараах үндэслэлээр бүртгэхээс татгалзана:

3.8.1. баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн нь тогтоогдсон;

3.8.2. эрх бүхий албан тушаалтан, гүйцэтгэх удирдлага болон түүний холбогдох этгээд нь хууль тогтоомжид заасан шалгуурыг хангаагүй;

3.8.3. хууль болон энэхүү журамд заасан нөхцөл, шаардлагыг хангаагүй;

3.8.4. үйл ажиллагаа явуулахад шаардагдах мөнгөн хөрөнгийг зээлийн эх үүсвэрээр бүрдүүлсэн нь нотлогдсон эсхүл хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан нь зээлийн гэрээ буюу баталгаагаар хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өртэй;

3.8.5. баримт бичгийн бүрдлийг хангаагүй, шаардлагад нийцэхүйц хэмжээнд бүрдүүлэх хуульд заасан хугацааг хэтрүүлсэн.

3.9. Өргөдөл гаргагч нь Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон энэхүү журамд заасан баримт бичгийн бүрдлийг хангаагүй, нотлох баримтын шаардлагыг хангахгүй болох нь үндэслэл бүхий баримтаар нотлогдсон тохиолдолд шаардлага хангахуйц нотлох баримт бичиг гаргуулахыг бүртгэх байгууллага хүсэлт гаргагчаас албан бичгээр шаардах бөгөөд хууль,

энэхүү журмаар тогтоосон шаардлагын дагуу нэмж бүрдүүлж ирүүлсэн өдрөөс эхлэн шийдвэрлэх хугацааг тооцно.

3.10. Бүртгэх байгууллага энэхүү журмын 3.8 дахь хэсэгт заасан үндэслэлээр татгалзсан тохиолдолд энэ талаар өргөдөл гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.

3.11. Бүртгэх байгууллага Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 11.9 дэх хэсэгт заасан үүргээ хэрэгжүүлээгүй бол өргөдөл гаргагчийг мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээр бүртгэсэнд тооцно.

3.12. Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 11.8 дахь хэсэгт заасан үндэслэлээр татгалзсан өдрөөс хойш өргөдөл гаргагчийн хүсэлтийг 1 жилийн дотор дахин хүлээн авахгүй.

3.13. Аймаг, нийслэлийн Засаг дарга мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, энэхүү журмын 4, 5, 6, 11 дүгээр бүлэгт заасан бүртгэлийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг сар бүрийн 05-ны өдрийн дотор цахим сангаар дамжуулан Хороонд тухай бүр нийлүүлнэ.

#### **Дөрөв. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгө, мөнгөн хөрөнгийн өөрчлөлтийг бүртгэх, бүртгэхээс татгалзах**

4.1. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгө, байнга ашиг олох зорилгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй иргэний мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь иргэний хувьд татвар төлсний дараах орлого, хуулийн этгээдийн хувьд жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлан, татварын тайлангаар баталгаажсан хуримтлагдсан ашиг, хөрөнгө борлуулсны орлого байна.

4.2. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд дараах байдлаар өөрчлөлт оруулна:

4.2.1. тайлант жилийн ашгаас хувьцаа эзэмшигчид хуваарилсан татвар төлсний дараах ногдол ашгаар нэмэгдүүлэх;

4.2.2. хувьцаа эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн татварын тайлан, татвар төлсний дараах хууль ёсны орлогоор нэмэгдүүлэх;

4.2.3. шинээр хувьцаа гаргах;

4.2.4. хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа бэлэглэх, өвлүүлэх, эсхүл бусад хувьцаа эзэмшигчид болон гуравдагч этгээдэд худалдах;

4.2.5. хууль болон холбогдох журамд заасан бусад хэлбэрээр нэмэгдүүлэх;

4.2.6. хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангах боломжтой, санхүү, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулснаар бусад хувьцаа эзэмшигч, харилцагчдад хохирол учруулахгүй бол хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хорогдуулах.

4.3. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, хувьцааг худалдан авагч нь хуулийн этгээд бол түүний эцсийн өмчлөгчийн овог, эцэг, /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, түүнд оруулсан өөрчлөлтийн талаарх мэдээллийг бүртгэх байгууллагад хүргүүлнэ.

4.3. Байнга ашиг олох зорилгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй иргэний мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь иргэний хувьд цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, үйл ажиллагааны орлого, хөрөнгийн орлого, хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого, бэлэглэх, өвлүүлэх, эсхүл бусад гуравдагч этгээдэд худалдсанаас үүсэх татвар төлсний дараах орлого байна.

4.4. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгө, байнга ашиг олох зорилгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй иргэний мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг өөрөө тодорхойлж, нотлох үүрэгтэй.

4.5. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь өөрчлөлт оруулж буй мөнгөн хөрөнгийг банкн дахь харилцах дансандаа байршуулж, банкны тодорхойлолт, дансны хуулгыг ирүүлэх бөгөөд бүртгэх байгууллагын шийдвэр гарахаас өмнө дансны үлдэгдлийг эрх бүхий этгээд шалган баталгаажуулж болно.

4.6. Мөнгөн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах хүсэлт гаргагч нь бүртгэх байгууллагын хүсэлтийг хянаж, шийдвэрлэх хүртэлх хугацаанд байршуулвал зохих мөнгөн хөрөнгийн хэмжээг бууруулж, зарлагын гүйлгээ хийхгүй.

4.7. Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-т заасан этгээдийн мөнгөн хөрөнгийн болон хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь хуулийн 9.2 дахь хэсэгт заасан хэмжээнд хүрсэн тохиолдолд Санхүүгийн зохицуулах хороонд өргөдөл гаргаж, бүртгүүлнэ.

4.8. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцааны тоо, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах хүсэлтээ энэхүү журмын хавсралтаар батлагдсан СЗХ09002 маягтын дагуу гаргасан өргөдөл, 2(Б) дугаар хавсралтад заасан баримт бичгийг бүрдүүлж, бүртгэх байгууллагад бичгээр болон цахимаар ирүүлнэ.

4.9. Байнга ашиг олох зорилгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй иргэн мөнгөн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах хүсэлтээ энэхүү журмын хавсралтаар батлагдсан СЗХ09002 дугаар маягтын дагуу гаргасан өргөдөл, 2(Б) дугаар хавсралтад заасан баримт бичгийг бүрдүүлж, бүртгэх байгууллагад бичгээр болон цахимаар ирүүлнэ.

4.10. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцааны тоо, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, байнга ашиг олох зорилгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй иргэн мөнгөн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах өргөдөл, баримт бичгийг бүртгэх байгууллага хүлээн авсан өдрөөс ажлын 15 хоногийн дотор хянаж, энэхүү журмын 3.6 дахь хэсэгт заасан эрх бүхий этгээдэд танилцуулан шийдвэрлүүлнэ.

4.11. Энэхүү журмын 4.10 дэх хэсэгт заасан эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн бүртгэлийн гэрчилгээний хавсралтад зохих тэмдэглэгээг хийлгэж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлсний үндсэн дээр мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах эрх үүснэ.

4.12. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь өөрчлөлт орсон улсын бүртгэлийн гэрчилгээ болон дүрмийн хуулбарыг бүртгэх байгууллагад хүргүүлнэ.

4.13. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцааны тоо, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, байнга ашиг олох зорилгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй иргэн мөнгөн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах хүсэлтийг дараах үндэслэлээр бүртгэхээс татгалзана:

4.13.1. өөрчлөлт оруулах хувь нийлүүлсэн хөрөнгө, мөнгөн хөрөнгө нь хууль ёсны орлого болох нь нотлогдоогүй;

4.13.2. энэхүү журмын 4.5 дахь хэсгийг зөрчиж, мөнгөн хөрөнгөөс зарлагын гүйлгээ хийсэн;

4.13.3. хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцааны тоо, өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн эрх бүхий этгээдийн шийдвэр болон гэрээ хэлцэл хуурамч болох нь тогтоогдсон;

4.13.4. баримт бичгийн бүрдлийг хангаагүй, шаардлагад нийцэхүйц хэмжээнд бүрдүүлэх хуульд заасан хугацааг хэтрүүлсэн.

4.14. Энэхүү журмын 4.13 дахь хэсэгт заасан үндэслэлээр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцааны тоо, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, байнга ашиг олох зорилгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй иргэн мөнгөн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулахаас татгалзсан тохиолдолд хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.

4.15. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцааны тоо, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, байнга ашиг олох зорилгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй иргэн мөнгөн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах хүсэлтийг бүртгэхээс татгалзсан тохиолдолд нөхцөл, шаардлага хангасан баримт бичгийг ажлын 10 хоногийн дотор ирүүлэх ба шаардлага хангасан баримт бичгийг ирүүлээгүй бол бүртгэхээс татгалзсанд тооцно.

4.16. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцааны тоо, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, байнга ашиг олох зорилгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй иргэн мөнгөн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах хүсэлтийг 4.12 дахь хэсэгт заасан үндэслэлээр татгалзсан өдрөөс хойш өргөдөл гаргагчийн хүсэлтийг 6 сарын дотор дахин хүлээн авахгүй.

**Тав. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээдийн салбар, оноосон нэрийн өөрчлөлтийг бүртгэх, бүртгэхээс татгалзах, бүртгэлээс хасах**

5.1. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээдийн салбар нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй бөгөөд хуулийн этгээдийн оршин байгаа газраас өөр газар байрлаж, түүний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах буюу түүний нэрийн өмнөөс хэлцэл болон эрх зүйн бусад үйлдэл хийнэ.

5.2. Салбар байгуулахыг хүссэн хуулийн этгээд нь энэхүү журмын хавсралтаар батлагдсан СЗХ09003 дүгээр маягтын дагуу гаргасан өргөдөл, (2В) дүгээр хавсралтад заасан баримт бичгийг бүрдүүлж, бүртгэх байгууллагад хэвлэмэл болон цахимаар ирүүлнэ.

5.3. Салбарын гүйцэтгэх удирдлага, боловсон хүчинд хуулийн 7.1 дэх хэсэгт заасан, үйл ажиллагаа явуулах ажлын байранд хуулийн 5.1.6-д заасан шаардлага мөн адил хамаарах бөгөөд энэхүү журмын 2.3, 2.6-д заасан баримт бичгийг бүрдүүлж, бүртгэх байгууллагад хэвлэмэл болон цахимаар ирүүлнэ.

5.4. Бүртгэх байгууллагын эрх бүхий албан тушаалтан хүсэлт гаргагчийн үйл ажиллагаа явуулах ажлын байр, тоног төхөөрөмж, программ хангамж нь энэхүү журмаар тогтоосон шаардлагыг хангасан эсэхийг газар дээр нь шалгаж, танилцаж болно.

5.3. Салбар байгуулах нь тухайн барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээдийн санхүүгийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, боловсон хүчин, техник тоног төхөөрөмж, програм хангамж нь тухайн салбарын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл, шаардлагыг хангасан гэж үзвэл ажлын 15 хоногийн дотор энэхүү журмын 3.6 дахь хэсэгт заасан эрх бүхий этгээдэд танилцуулан шийдвэрлүүлнэ.

5.4 Салбар тус бүр гэрчилгээтэй байх ба энэхүү журмын 5.3 дахь хэсэгт заасан эрх бүхий этгээдийн шийдвэрийг үндэслэн бүртгэлийн гэрчилгээний хавсралтад зохих тэмдэглэгээг хийлгэж, Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлснээр үйл ажиллагаа явуулах эрх үүснэ.

5.5. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь 5.4 дэх хэсэгт заасан өөрчлөлтийг улсын бүртгэлийн гэрчилгээ болон дүрмийн хуулбарыг бүртгэх байгууллагад хүргүүлнэ.

5.6. Бүртгэх байгууллага дараах үндэслэлээр ББСБ-ын салбарыг бүртгэхээс татгалзаж, энэ тухай тайлбарыг хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ:

5.6.1.хяналт шалгалтын дүгнэлтийг үндэслэн;

5.6.2.баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн нь тогтоогдсон;

5.6.3.хууль тогтоомжид заасан нөхцөл, шаардлагыг хангаагүй;

5.6.4.баримт бичгийн бүрдлийг хангаагүй, шаардлагад нийцэхүйц хэмжээнд бүрдүүлэх хуульд заасан хугацааг хэтрүүлсэн.

5.7. Салбар байгуулах хүсэлтийг бүртгэхээс татгалзсан тохиолдолд нөхцөл, шаардлага хангасан баримт бичгийг ажлын 5 хоногийн дотор ирүүлэх ба шаардлага хангасан баримт бичгийг ирүүлээгүй бол салбарыг бүртгэхээс татгалзсанд тооцно.

5.8. Энэхүү журмын 5.6 дахь хэсэгт заасан үндэслэлээр салбар байгуулах хүсэлтийг татгалзсан тохиолдолд уг өдрөөс хойш 6 сарын хугацаанд бүртгэх байгууллага дахин хүсэлтийг хүлээн авахгүй.

5.9. Салбарыг татан буулгах, өөрчлөн байгуулах шийдвэр гаргасан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор бүртгэх байгууллагад албан бичгээр мэдэгдэнэ.

5.10. Салбарыг дараах үндэслэлээр бүртгэлээс хасч, гэрчилгээг хураан авна:

5.10.1.татан буулгах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр;

5.10.2.хууль тогтоомжид нийцээгүй үйл ажиллагаа явуулсан нь тогтоогдсон;

5.10.3.салбарын үйл ажиллагаа нь тухайн хуулийн этгээдийн хэвийн үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадварт хүндрэл учруулахаар байгаа нь тогтоогдсон;

5.10.4.хяналт шалгалтаар өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй;

5.10.5.хууль тогтоомжид заасан бусад.

5.11. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг бүртгэлээс хассан тухай эрх бүхий этгээдийн шийдвэр нь салбарыг бүртгэлээс хасах үндэслэл болно.

5.12. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээдийн оноосон нэр өөрчлөх хүсэлтийг энэхүү журмын хавсралтаар батлагдсан СЗХ09004 маягтын дагуу гаргасан өргөдөл, (2Г) дүгээр хавсралтад заасан баримт бичгийг бүрдүүлж, бүртгэх байгууллагад хэвлэмэл болон цахимаар ирүүлнэ.

5.13. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээдийн оноосон нэрийг өөрчлөх нь харилцагчдад сөргөөр нөлөөлөхгүй, төөрөгдүүлэхгүй гэж үзвэл ажлын 15 хоногийн дотор энэхүү журмын 3.6 дахь хэсэгт заасан эрх бүхий этгээдэд танилцуулан шийдвэрлүүлнэ.

5.14. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээдийн оноосон нэрийг өөрчлөхийг зөвшөөрсөн шийдвэрийг болон Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан хураамжийг төлсөн баримтыг үндэслэн гэрчилгээг шинэчлэн олгох бөгөөд Улсын бүртгэлийн байгууллагад холбогдох бүртгэлийг хийлгэж, өөрчлөлт орсон улсын бүртгэлийн гэрчилгээ болон дүрмийн хуулбарыг бүртгэх байгууллагад хүргүүлнэ.

**Зургаа. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээдийн гүйцэтгэх удирдлага, хаяг байршилын өөрчлөлтийг бүртгэх, бүртгэхээс татгалзах**

6.1. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээдийн гүйцэтгэх удирдлага, хаяг байршил өөрчлөгдсөн тохиолдолд энэхүү журмын хавсралтаар батлагдсан СЗХ09005 маягтын дагуу гаргасан өргөдөл, (2Д) дүгээр хавсралтад заасан баримт бичгийг бүрдүүлж, бүртгэх байгууллагад хэвлэмэл болон цахимаар ирүүлнэ.

6.2. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээдийн гүйцэтгэх удирдлагатай холбоотой хуулийн 7.2, 7.3-т заасан нөхцөл байдал үүссэн тухай бүрт бүртгэх байгууллагад мэдээлж, өөрчлөлтийг холбогдох бүртгэлд бүртгүүлнэ.

6.3. Гүйцэтгэх удирдлага, хаяг байршил өөрчилсөнтэй холбоотой ирүүлсэн хүсэлт, баримт бичгийг хянаж, хуулийн 11.10-т заасан бүртгэлийн цахим санд ажлын 10 хоногийн дотор бүртгэнэ.

6.4. Энэхүү журмын 2.3, 2.6-д заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд гүйцэтгэх удирдлага, хаяг байршилын өөрчлөлтийг бүртгэхээс татгалзана.

6.5. Байнга, ашиг олох зорилгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэний хаяг байршил өөрчлөгдсөн тохиолдолд бүртгэх байгууллагад мэдээлж, өөрчлөлтийг холбогдох бүртгэлд бүртгүүлнэ.

**Долоо. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээд финтек технологи ашиглан зээлийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлага**

7.1. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээд дэвшилтэт технологийн шийдэл ашиглан цахим /цаашид “финтек” гэх/-аар зээлийн бүтээгдэхүүн гаргах тохиолдолд хуулийн 9.2-т заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 2.5 тэрбум төгрөгөөс доошгүй байна.

7.2. Финтек зээлийн бүтээгдэхүүний хувьд Хорооноос тогтоосон өр, орлогын харьцаа, эргэн төлөгдөх чадварыг харгалзана.

7.3. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээд нь финтек зээлийн бүтээгдэхүүн гаргахад мэдээллийн технологийн хувьд дараах шаардлагыг хангасан байна:

7.3.1. кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хийлгэж баталгаажуулсан байх;

7.3.2. MNS ISO/IEC 27001:2021 стандартыг хангасан Мэдээллийн аюулгүй байдлын аудитыг хийлгэж баталгаажуулсан байх.

7.3.3. Зээлийн мэдээллийн санд зээлдэгчийн мэдээллийг нийлүүлдэг байх;

7.4. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээд нь финтек зээлийн бүтээгдэхүүн гаргах тохиолдолд энэ журмын 7.3-т заасан шаардлагыг хангасан гуравдагч этгээдээс аутсорсингийн үйлчилгээ авч болно.

7.5. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээд нь аутсорсингийн үйлчилгээ үзүүлэгч компанитай байгуулах гэрээнд үйлчилгээтэй холбоотой гарах аливаа эрсдэлийг хариуцах зохицуулалтыг тусгасан байна.

7.6. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээд нь финтек зээлийн бүтээгдэхүүнийг бүртгүүлэхдээ дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ:

7.6.1. хүсэлт тавьсан албан бичиг;

7.6.2. финтек зээлийн бүтээгдэхүүний талаарх танилцуулга;

7.6.3. энэ журмын 7.3-т заасан шаардлагыг хангасныг нотлох баримт бичиг;

7.6.4. аутсорсингийн үйлчилгээгээр авч буй тохиолдолд тухайн гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээ болон бусад холбогдох баримт бичиг.

7.7. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээд нь Хорооны холбогдох нэгжид финтек зээлийн бүтээгдэхүүний талаар болон энэ журмын 7.3-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаарх танилцуулгыг хийнэ.

7.8. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээдээс ирүүлсэн баримт бичигтэй холбоотойгоор нэмэлт тодруулга шаардлагатай тохиолдолд албан бичгээр мэдэгдэх бөгөөд нэмэлт баримт бичиг ирүүлсэн өдрөөс эхлэн шийдвэрлэх хугацааг тооцно.

7.9. Хорооны холбогдох нэгжээс финтек зээлийн бүтээгдэхүүний энэ журмын 7.3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан эсэх талаарх дүгнэлт гаргаж, ажлын 15 хоногт багтаан бүртгэж, хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.

7.10. Энэхүү журмын 7.9 дахь хэсэгт заасан дүгнэлтийг үндэслэн финтек зээлийн бүтээгдэхүүнийг бүртгэлийн цахим санд бүртгэж, нийтэд мэдээлнэ.

7.11. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээд нь программ хангамжид аливаа нэмэлт шинэчлэлт хийн финтек зээл гаргах бүрд Хороонд бүртгүүлнэ.

7.12. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээдийн финтек зээлийн бүтээгдэхүүнийг дараах тохиолдолд бүртгэлээс хасна:

7.12.1. баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн нь тогтоогдсон;

7.12.2.энэхүү журамд заасан бусад нөхцөл, шаардлагыг хангаахгүй болсон;

7.12.3.зээлдэгчийн нууцад хамаарах мэдээллийг задруулсан, хууль бусаар ашигласан нь тогтоогдсон.

7.13. Энэхүү журмын 7.3, 7.12 дахь хэсэгт заасан үндэслэлээр финтек зээлийн бүтээгдэхүүнийг бүртгэхээс татгалзсан, бүртгэлээс хассан бол тухайн барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээдээс финтек зээлийн бүтээгдэхүүн гаргах хүсэлтийг 1 жилийн дотор дахин хүлээн авахгүй.

### **Найм. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээдийн үйл ажиллагаа**

8.1.Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээд мөнгөн зээлийн үйл ажиллагаандаа дараах хэм хэмжээг баримталж, үйлчилгээ үзүүлнэ:

8.1.1.Монгол улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх бөгөөд сэтгэцийн өвчтэй, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис согтууруулах ундаа хэрэглэсэн, насанд хүрээгүй, зээлдэгчээс бусад этгээдийн бичиг баримтаар үйлчилгээ үзүүлж болохгүй.

8.1.2.ажлын байранд өөрийн оноосон нэр, хаяг, холбоо барих утас, бүртгэлийн гэрчилгээ, үйлчилгээний нөхцөл, цагийн хуваарь, хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан зар сурталчилгааг үйлчлүүлэгчдэд ил харагдахуйц байрлуулна.

8.1.3.үйлчилгээ үзүүлэхийн өмнө зээлийн бүтээгдэхүүний нөхцөл, зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүү, хүү тооцох аргачлалын талаар тогтмол танилцуулж, үйлчлүүлэгчийг мэдээлэл авах боломжоор хангана.

8.1.4.барьцаа хөрөнгийн үнэлгээг зах зээлийн жишиг үнийг харгалзан хуулийн 17.4-т заасан Мөнгөн зээлийн үйл ажиллагааны бодлогын зөвлөлөөс баталсан үнэлгээний аргачлалыг ашиглан үйлчлүүлэгчтэй гэрээгээр харилцан тохиролцсоны үндсэн дээр тогтооно.

8.1.5.Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйл, 15.10, 16.3, 18.7-д заасан хориглосон үйл ажиллагаа явуулахгүй.

8.1.6.зээлдэгч болон гуравдагч этгээд нууц гэж үзсэн аливаа мэдээллийг тухайн этгээд бичгээр өөрөө зөвшөөрсөн, бүртгэх байгууллага хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан, шүүх, прокурорын байгууллагын удирдлага хүсэлт гаргасан, эсхүл авилгатай тэмцэх байгууллага, цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны болон тагнуулын байгууллага мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдсон мэдээллийг шалгах шаардлагаар мөрдөгчийн саналыг прокурор зөвшөөрсөнөөс бусад тохиолдолд бусад этгээдэд гаргаж өгөх, задруулах, ашиглуулах, олон нийтэд мэдээлэхийг хориглоно.

8.2.Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээд зээлдэгчтэй харилцахад дараах хэм хэмжээг баримтална:

8.2.1.зээлийн, барьцааны болон батлан даалтын гэрээ нь Иргэний хуулийн 281-283 дугаар зүйл, 156-160 дугаар зүйл, 458-465 дугаар зүйл, Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 15.2, 15.4 дэх хэсэгт заасан гэрээний эрх зүйд нийцсэн байна.

8.2.2.гэрээнд зээлийн хэмжээ, хүү, хугацаа, нэмэгдүүлсэн хүү, хүү тооцох аргачлал, зээл олгох хэлбэр, зээлийн гэрээний хугацааг сунгах, зээлийг урьдчилан төлөх нөхцөл, барьцааны хөрөнгийн үнэлгээ, үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга, хохирлыг барагдуулах болон холбогдох бусад нөхцөлийн талаар зээлдэгчтэй харилцан тохиролцож байгуулсан зээлийн гэрээний үндсэн дээр зээл олгох ба гэрээний хуудсыг дугаарлан баталгаажуулж 2 хувь үйлдэнэ.

8.2.3.хуулийн 15.3, 15.5 дахь хэсэгт заасны дагуу зээлдэгчид зээлийн, барьцааны болон батлан даалтын гэрээний нөхцөлийг тайлбарлаж өгч, үйлчилгээ үзүүлнэ.

8.2.4.зээлийн хүүг хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу зохицуулах бөгөөд гэрээний хугацаа дуусгавар болоогүй байхад зээлдэгчтэй харилцан тохиролцсон хүүгийн хэмжээнд өөрчлөлт оруулж болохгүй.

8.2.5.зээлдэгч барьцаалах эд хөрөнгийг өөрийн өмч болохыг нотлоогүй, хамтран эзэмшигчээс зөвшөөрөл аваагүй бол үйлчилгээ үзүүлэхээс татгалзана.

8.2.6.барьцаалан зээлдүүлэх гэрээний хугацаа дуусгавар болохоос өмнө эсхүл дууссаны дараа энэ тухай зээлдэгчид мэдэгдэл, нэхэмжлэлийг түүний харилцах утас эсхүл шуудангийн хаяг зэрэг арга хэрэгслийг ашиглан мэдэгдэнэ.

8.2.7.зээлийн ашигласан хугацаа нь зээлдүүлэгчээс зээлдэгчид гэрээнд тохиролцсон хэлбэрээр зээл олгосноор эхэлж, зээлдэгч зээлдүүлэгчид буцаан төлснөөр дуусгавар болно.

8.2.8.зээлдэгч, зээлдүүлэгч нь барьцаалан зээлдүүлэх гэрээгээр хүлээсэн үүрэг зохих ёсоор биелүүлэх бөгөөд зээлдэгч барьцаат зээлээ төлсөн, эсхүл хууль, зээлийн гэрээнд заасны дагуу зээлийн гэрээний үүрэг дуусгавар болсон тохиолдолд зээлдүүлэгч зээлдэгчийн зээлийн дансыг хааж, зээлийн барьцаа хөрөнгийг чөлөөлнө.

8.2.9.иргэн, хуулийн этгээдийн хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгөтэй холбоотой гэрээ, хуульд зааснаар үүсэх барьцааны харилцаанд Хөдлөх эд хөрөнгө эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийг дагаж мөрдөх бөгөөд эрхийн доголдолгүй барьцаа хөрөнгийг хүлээн авч, түүний чанар, бүрэн бүтэн байдлыг шалгаж, барьцаалах эд хөрөнгөд анхны үнэлгээ хийнэ.

8.2.10.галт зэвсэг, хэрэгсэл, сум, тэсэрч дэлбэрэх зүйл, хорт болон химийн бодис, хүнсний бүтээгдэхүүн, иргэний ба албаны үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичиг, хуулийн

этгээдийн аливаа үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, лиценз, бусад эрхийн бичиг, архелог, палентлогийн олдвор, төрийн одон, медаль, бусад шагналын зүйлийг барьцаанд авахгүй.

8.2.11. барьцаалсан хөдлөх эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж, барьцаанд тавьсан эд зүйлийг гадна талаас нь харагдах тунгалаг уут, саванд хийж үйлчлүүлэгчийн дэргэд битүүмжлэн тусгай тэмдэглэгээ тавьж лацдана.

8.2.12. зээлдэгчийн эд хөрөнгийг барьцаанд хүлээн авах, буцаан олгохдоо хүлээлцсэн тухай актыг бичгээр үйлдэнэ.

8.2.13. автомашин барьцаалсан тохиолдолд Иргэний хуулийн 235 дугаар зүйлд заасны дагуу фидуцийн гэрээ байгуулах бөгөөд барьцаанд хүлээн авсан эд хөрөнгийг учирч болзошгүй эрсдлээс хамгаалах зорилгоор даатгуулж болно.

8.2.14. барьцаалсан эд хөрөнгийг гэрээгээр тогтоосон хугацаанд бусад эд хөрөнгөөс тусад нь хадгалах ба аливаа хэлбэрээр ашиглах, дур мэдэн захиран зарцуулж болохгүй.

8.2.15. зээлдэгч гэрээний зээлийн үндсэн төлбөр, хүүгийн төлбөрийг хугацаанд нь буцаан төлөөгүй тохиолдолд зээлдүүлэгч хуулийн 16.5-д заасан мэдэгдэл хүргүүлсэх бөгөөд ийнхүү мэдэгдэл хүргүүлснээс хойш үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд Хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 53 дугаар зүйлд заасны дагуу худалдан борлуулах замаар үүргийн гүйцэтгэлийг хангуулж, үнийн дүнгээс зээлийн болон хүүгийн төлбөрийг суутгаж, үлдсэн төлбөрийг зээлдэгчид буцаан олгоно.

8.2.16. хуулийн 22.1 дэх хэсэгт заасны дагуу санаатай болон болгоомжгүй үйлдлээр зээлдэгчид хохирол учруулсан, эсхүл энэхүү журмыг зөрчиж олгосон зээлтэй холбоотой үүссэх хохирлыг бүрэн хариуцана.

8.2.17. барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээд Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан бүртгэлийн дэвтэр хөтлөх журам, загварын дагуу дотоод бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж, цахим санд мэдээлэх бөгөөд бүртгэлийн дэвтэрт зээлдэгчээр гарын үсэг зуруулж баталгаажуулсан байна.

8.2.18. барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээд энэхүү журмын 8.2 дахь хэсэгт заасан бүртгэлийн дэвтэр, зээлдэгчийн зээлийн хувийн хэрэгт холбогдох баримт бичгийг 3 жилийн хугацаанд хадгална.

8.3. Байнга ашиг олох зорилгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй иргэнд энэхүү журмын 8.1.1, 8.1.3-8.1.6, 8.2.1-8.2.16-д заасан зохицуулалт мөн адил хамаарах бөгөөд үл хөдлөх хөрөнгө барьцаалсан тохиолдолд барьцаа хөрөнгийг улсын бүртгэлд бүртгүүлж, цахим санд мэдээлсэн байна.

### **Ес. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээдийн тайлан**

9.1. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээдийн санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан бүрэлдэхүүнтэй байх бөгөөд санхүүгийн тайлан, татварын тайланг хагас бүтэн жилээр гаргаж, дараа сарын 20-ны өдрийн дотор харьяалах санхүүгийн байгууллага, татварын байгууллагад тайлагнана.

9.2. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээд нь 23.8 дахь хэсэгт заасан мэдээллийг Хорооноос баталсан маягтын дагуу хагас, бүтэн жилээр гаргаж, дараа сарын 20-ны өдрийн дотор бүртгэх байгууллагад цахимаар хүргүүлнэ.

9.3. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээд нь 23.8 дахь хэсэгт заасан мэдээлэлтэй холбогдсон нэмэлт нотлох баримт, тодруулгыг мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээдээс бүртгэх байгууллага шаардах эрхтэй ба тайлбар, тодруулгыг цаг хугацаанд нь үнэн зөв, бүрэн гаргаж өгнө.

9.4. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээд нь 23.8 дахь хэсэгт заасан мэдээллийн үнэн зөв эсэхэд бүртгэх байгууллага хяналт тавьж, зохих журмыг баримтлаагүй, буруу, ташаа, алдаатай бол залруулахыг шаардаж, биелэлтэд хяналт тавьж ажиллана.

9.5. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээд нь санхүүгийн тайланг шаардлагатай тохиолдолд аудитын байгууллагаар баталгаажуулж, бүртгэх байгууллагад ирүүлнэ.

#### **Арав. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих**

10.1. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээдийн хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаа байдалд Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 24.2-г заасан хянан шалгагч, аймаг, нийслэлд Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Засаг даргатай харилцан зөвшилцсөний дагуу Хорооны Улсын ерөнхий байцаагчийн томилсон хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий этгээд хяналт тавина.

10.2. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаагийн байгууллага, орлогын албан татвар төлөлтөд татварын байгууллага, ажлын байрны стандарт, аюулгүй байдалд мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавина.

10.3. Хорооны Улсын ерөнхий байцаагчийн томилсон хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий этгээд нь хяналт шалгалтын чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

10.3.1. хяналт шалгалтын дүнг үндэслэн акт тогтоох, түүний гүйцэтгэлийг хангуулах, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар хугацаатай үүрэг, албан шаардлага өгч, биелэлтийг хангуулах;

10.3.2. энэ журмын 10.3.1-г заасан үүрэг, албан шаардлагыг биелүүлээгүй, эсхүл хяналт шалгалтын явцад хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн нь нотлогдсон тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээлгэх, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоох, энэ тухай нийтэд мэдээлэх, шаардлагатай гэж үзвэл бүртгэлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох саналыг энэ журмын 3.6-д заасан эрх бүхий этгээдэд танилцуулж, шийдвэрлүүлэх;

10.3.3. тайлан, мэдээнд үндэслэн үйл ажиллагааны болон цаашид үүсч болзошгүй эрсдэлийн түвшинг тогтоох, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх, тайлан, мэдээллийг ирүүлээгүй, ирүүлсэн тайлан, мэдээлэл нь шаардлага хангаагүй бол шаардлага хангасан тайлан мэдээг нэн даруй ирүүлэхийг шаардах;

10.3.4. зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, судалгаа, бусад баримтыг хадгалж байгаа ажлын байранд нэвтрэн орж, үзлэг хийх, тооллого явуулах, баримт бичиг, эд хөрөнгийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу хураах, хяналт шалгалтын ажил хийх;

10.3.5.хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай магадалгаа, баримтын хуулбар, мэдээ, судалгаа, дансны хуулга, холбогдох бусад баримт бичиг, мэдээллийг үнэ төлбөргүй гаргуулан авах;

10.3.6.бүртгэлгүйгээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, хуулийн этгээдийн ажлын байранд нэвтрэх, биед нь үзлэг шалгалт хийх, үйл ажиллагааг шалгах, таслан зогсоох, хууль бусаар олсон орлогыг хураах;

10.3.7.хуульд заасны дагуу Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага оногдуулах;

10.3.8. хууль тогтоомжид заасан бусад.

10.4. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээдэд хийх хяналт шалгалт нь зайны, газар дээрх хяналт шалгалт гэсэн төрөлтэй байх ба газар дээрх шалгалтыг үйл ажиллагааны хамрах цар хүрээгээр нь иж бүрэн, хэсэгчилсэн гэж ангилна:

10.4.1.иж бүрэн шалгалт нь баталсан удирдамжийн хүрээнд мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үйл ажиллагааг бүхэлд нь хамруулж нарийвчлан шалгаж, үнэлэлт, дүгнэлт өгөх;

10.4.2.хэсэгчилсэн шалгалт нь харилцагчдаас болон холбогдох бусад байгууллагаас ирсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан шүүмжлэлийн мөрөөр, эсхүл бүртгэх байгууллагаас шалгах шаардлагатай гэж үзсэн этгээдийн үйл ажиллагааны тодорхой хэсгийг шалгаж үнэлэлт, дүгнэлт өгөх.

10.5. Хяналт шалгалтын тайланг мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээдэд этгээдэд танилцуулж, шалгалтын хэсгийн гишүүд, улсын байцаагч гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулах бөгөөд шалгалтын дүнг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд үнэлгээтэй танилцсанаас хойш 10 хоногийн дотор Хорооны Улсын Ерөнхий байцаагчид бичгээр гомдол гаргаж болно.

10.6. Аймаг, нийслэлийн Засаг дарга мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хийсэн хяналт шалгалтын тайлан мэдээллийг сар бүрийн 05-ны өдрийн дотор цахим сангаар дамжуулан Хороонд тухай бүр нийлүүлнэ.

**Арван нэг. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээдийн үйл ажиллагааг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох**

11.1. Бүртгэх байгууллага нь мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй этгээдийн үйл ажиллагааг хуулийн 24.1 дэх хэсэгт заасан болон дараах үндэслэлээр 1 жил хүртэлх хугацаагаар түдгэлзүүлнэ:

11.1.1.хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан нь үндэслэл бүхий баримтаар тогтоогдсон;

11.1.2.үйл ажиллагаа нь доголдож, санхүү төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлж болзошгүй нөхцөл байдал үүссэн;

11.1.3.Хорооноос тогтоосон журмыг зөрчиж, тайлан, мэдээг хугацаанд нь 2 улирал дараалан ирүүлээгүй, хяналт, шалгалт хийх боломжгүй болгосон;

11.1.4.хувь нийлүүлсэн хөрөнгө, мөнгөн хөрөнгийн доод хэмжээг хангаж ажиллаагүй;

